**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ**

2025 оны 05 сарын 09 өдөр　　Дугаар 110　　Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Салхи энтертейнмент ХХК-ийн Монгол Улсын нутаг дэвсгэрт “Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх” 12800006 тоот тусгай зөвшөөрлийн хамрах хүрээг Улаанбаатар хотын нутаг дэвсгэр болгож, “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” 22800057 тоот тусгай зөвшөөрлийн хамрах хүрээнээс Улаанбаатар хотын Налайх дүүрэг, Дархан-Уул аймгийн Дархан сум, Орхон аймгийн Баян-өндөр сумын нутаг дэвсгэрийг хасаж, Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт болгож тус тус өөрчлөлт оруулсугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулсан тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй зөвшөөрлийн гэрээг шинэчлэн байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА　　Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮД　　Б.АНХБААТАР

Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР